БАТЛАВ
“ДЦС-4” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Х.ТӨМӨРХУЯГ

БАТЛАВ
“ТЭНҮҮН ӨЛЗИЙ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.БУЯН-ӨЛЗИЙ

# ХАЯГДАЛ ЗЭС, ГУУЛЬ ХУДАЛДАХ ГЭРЭЭ

2021 он 5 дугаар сарын 6-ны өдөр № 1/2021-175 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “ДЦС-4” ТӨХК-г төлөөлж БҮЭ-ны дэд захирал Б.Сандуйжав */цаашид худалдагч гэх/* нөгөө талаас “ТЭНҮҮН ӨЛЗИЙ” ХХК-НИЙ ЗАХИРАЛ Д.БУЯН-ӨЛЗИЙ цаашид худалдан авагч гэх/ нар нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтуудыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## Нэг. Нийтлэг зүйл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь “ТЭНҮҮН ӨЛЗИЙ” ХХК-ний үнийн саналыг үндэслэн ЗЭС БОЛОН ГУУЛЬ худалдан авахад ачих, тээвэрлэх, жинлэх нөхцлийг хангах ба тээврийн хэрэгслийг орж гарахад хяналт тавих төлбөрийг цаг хугацаанд нь гэрээнд заасны дагуу төлөх, гэрээт хугацаа эхлэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

## Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажсанаар гэрээ хууль зүйн хүчин төгөлдөр болж, худалдах худалдан авах ажиллагаа эхлэнэ.
2.2 Худалдах ба худалдан авах ажиллагаа нь 30 хоногийн хугацаатай байна.
2.3 Хоёр тал харилцан тохиролцсны үндсэн дээр гэрээний гүйцэтгэлийн хугацааг сунгаж болно.

## Гурав. Төлбөр тооцоо

3.1 Хаягдал зэсийг ялгаж сорчлохгүйгээр бөөнд нь 1 кг-ийг 8800 төгрөг, хаягдал гуулийг 1кг-ийг 3630 төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. Энэ үнэнд НӨАТ шингэсэн болно.
3.2 Хаягдал төмөр ачих машинаа баталгаатай авто пүүнд жинлүүлэн,төлбөрийг тухай бүрд нь ДЦС-4 ТӨХК-н кассанд тушаана.
3.3 Хаягдал зэс гуульны жингийн хорогдлыг бодит байдалд тулгуурлан генераторын ороомог 30%-аар, трансформаторын ороомог 10%, хаягдал гуулин труба 10% тус тус тооцно.

## Дөрөв. Худалдан авагчийн үүрэг

4.1 Худалдан авагч нь ДЦС-4 ТӨХК-нд дараахь дугаартай тээврийн хэрэгсэлийг нэвтрүүлнэ Үүнд: 46-08 УБВ Тээврийн хэрэгсэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана. Замын хөдөлгөөний дүрмийг чанд сахиж ажиллана.
4.2 Худалдан авагч нь харуулын постоор зөвшөөрлийн дагуу орж, гарахдаа станцын нутаг дэвсгэрт дотоод журмыг мөрдөнө.
4.3 Худалдан авагч нь боруулалтын мэргэжилтний зааж өгсөн хаядал зэс, гуулийг ачих үүрэгтэй бөгөөд дур мэдэн ачилт хийхгүй байх

худалдагч : худалдан авагч:

## Тав. Худалдагчын үүрэг

5.1 Худалдагч нь худалдан авагч талын харуулаар орох гарахад хяналт тавьж зэс болон гууль Станцын БМА-ны борлуулалтын мэргэжилтэн ачилтанд тогтмол хяналт тавьж ачилтыг зохион байгуулна

5.2 Харуулын постоор нэвтрэх тээврийн хэрэгсэл, ажиллах хүчний зөвшөөрлийг хууль журмын дагуу хүндрэл чирэгдэлгүй шуурхай зохион байгуулах .

## Зургаа. Хоёр талын эрх

6.1 Гэрээнд заасны дагуу худалдан авах ажиллагаанд хоёр талын эрх бүхий хүмүүс тухай бүр нь хянаж баталгаажуулж байна.

6.2 Гэрээнд зааснаас өөр үйлдэл хийх буюу эд зүйлийг эвдсэн, хулгайлсан, архи уусан зэрэг бусад хэв журмын зөрчил гаргасан тохилдолд гэрээг цуцлах эрхтэй.

6.3 Техник Хяналтын Хэлтсийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсэргүүцсэн тохиолдолд гэрээг цуцлуулах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Худалдагч талыг төлөөлж:

"ДЦС-4" ТӨХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
.......................................Б.ГАНХУЯГ

БЕЗНИС ХАРИУЦСАН ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ.............................Б.САНДУЙЖАВ
/2021 ОН ...САР...ӨДӨР/

"ДЦС-4" ТӨХК-ИЙН БМА-НЫ ДАРГА
.......................................С.АЛТАНХУЯГ
/2021 ОН 04 САРЫН 20 ӨДӨР/

"ДЦС-4" ТӨХК-НИЙ СБХ-ИЙН ДАРГА
.......................................Д.ТӨМӨРТОГОО
/2021 ОН 04 САРЫН 23 ӨДӨР/

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ
.......................................Ч. БЯМБАСҮРЭН
/2021ОН...САРЫН...ӨДӨР/

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН
.......................................С.ДОНИД
/2021 ОН 4 САРЫН 23 ӨДӨР/

Худалдан авагч талыг төлөөлж:

"ТЭНҮҮН ӨЛЗИЙ"ХХК- ИЙН ЗАХИРАЛ Д.БУЯН-ӨЛЗИЙ
.......................................
2021 ОНЫ.....САРЫН....ӨДӨР

ХОЁР ТАЛЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

Монгол улс,
16100 Улаанбаатар хот
Баянгол дүүрэг, 20 дугаар хороо
"ДЦС-4" ТӨХК
Утас: 70170783
ДАНС:ДЦС- 4 ТӨХК КАСС

Худалдан авагчийн хууль ёсны хаяг, утас, факс, РД:2721317 ХУД -ийн 3-р хороо ажилчны гудамж
Утас №88676719,89993666:

худалдагч :

худалдан авагч: